



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.01.26 № 05

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны
224, 225 дугаар тогтоолын талаар

Монгол Улсын Засгийн газраас боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдын цалингийн доод хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох ёстой байсан ч энэхүү эрх хэмжээгээ харгалзах салбарын сайд нарт нь шилжүүлсэн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолыг гаргажээ. Мөн энэ тогтоолын дагуу салбарын сайд нар нь цалингийн хэмжээгээ нэмэгдүүлэн тогтоохтой холбоотойгоор төрийн албан хаагчдад нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох нийтлэг харилцааг зохицуулж байдаг Засгийн газрын 2018 оны 382 дугаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 225 дугаар тогтоолыг баталсан байна.

Засгийн газрын дээрх шийдвэрүүдтэй холбоотойгоор боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид болон багш нарын үйлдвэрчний эвлэлийн зүгээс ирсэн санал гомдлууд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд “Шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг салбарын хамтын хэлэлцээр, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн батлагдсан төсөвтөө багтаан нэмэгдүүлэн тогтоохыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр нарт зөвшөөрсүгэй.” гэсэн нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14-т “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.” гэсэн заалтыг зөрчсөн эсэх, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, эрх хэмжээнд салбар, салбарынхаа ажилтан, албан хаагчдын цалинг бие даан нэмэгдүүлэх эрх хэмжээ байдаг эсэх талаарх хууль зүйн тайлбарыг;

2026000013

2.Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн эрх хэмжээнд тус тусын салбарын ажилтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох эрх хэмжээ хуулиар олгогдоогүй тохиолдолд Засгийн газраас 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр гаргасан “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоол эрх зүйн үндэслэлгүй, хууль бус тогтоол болж таарна. Энэ тохиолдолд Засгийн газраас тус тогтоолоо хүчингүй болгож, шинээр дээрх салбаруудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын тогтоолыг гаргах тодорхой цаг хугацааны талаарх мэдээллийг;

3.Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 225 дугаар тогтоол батлагдсанаар боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу олгогддог төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, мэргэшлийн зэргийн нэмэгдэл, орон нутгийн нэмэгдэл, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл зэрэг нэмэгдлүүдийг тус тусын салбарын сайдын баталсан цалингийн хэмжээнээс биш Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн доод хэмжээ, сүлжээнээс тооцож олгохоор зохицуулсан нь боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс нэмэгдэх хүлээлтэнд хүрэхгүй, эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр болсон. Энэхүү шийдвэрээ эргэн харж, ямар зохицуулалт хийх гэж буй талаарх тайлбар мэдээллийг;

4.Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид ийнхүү Засгийн газраас тогтоосон цалингийн доод хэмжээ, сүлжээ, салбар тус бүрийн сайдын тогтоосон өөр нэг цалингийн хэмжээ, сүлжээтэй буюу хоёр өөр цалингийн хэмжээ, сүлжээтэй болсноор зөвхөн цалингийн нэмэгдэл авах эрх зүйн байдал нь дордохоос гадна Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт заасан тэтгэвэр тогтоолгохдоо авдаг нэг удаагийн буцалтгүй тусламж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.4-т заасан хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласныг урамшуулдаг 5, 3 жилийн тэтгэмжийг сайдын тушаалаар нэмэгдсэн цалингаас биш Засгийн газрын тогтоолтой цалингийн доод хэмжээнээсээ тооцуулж бодох бодит эрсдэл үүсээд байна. Тухайлбал, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.3-т “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын 3.2-т “Тэтгэмжийн хэмжээг Засгийн газраас тогтоосон албан тушаалын үндсэн цалингийн хэмжээгээр тооцно.” гэж тус тус заасан нь дээрх эрсдлийн нотолгоо гэж үзэж байна. Иймд энэхүү асуудлыг хэрхэн зохицуулах гэж буй талаарх тайлбар мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

2026000013

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ “Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан нь Засгийн газар гагцхүү хууль хэрэгжүүлэх, биелүүлэх үүрэгтэйг тодотгож байх ба Улсын Их Хурлын гишүүний энэхүү асуулга ч Засгийн газрыг Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардсан шаардлага гэж ойлгож болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

7026000013